



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 05

Даланзадгад

Шинэ баг /шинэ тосгон/ төслийг хэрэгжүүлэх
чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.7, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн “Шинэ баг төсөл”-ийг удирдан зохион байгуулах зөвлөлийг нэгдүгээр, эв нэгдэл, хөгжлийн төлөө төслийн уриалгыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ахлуулсан “Шинэ баг төсөл”-ийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийг сум тус бүр байгуулсугай.

3. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан 2018 оны хоёрдугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж, хэрэгжүүлэн ажиллахыг “Шинэ баг төсөл”-ийг зохион байгуулах зөвлөл /Х.Сугир/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Х.СУГИР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар
тогтоолын нэгдүгээр хэвсрэлт



**“Шинэ баг төсөл”-ийг удирдан зохион байгуулах
зөвлөлийн бүрэлдэхүүн**

Зөвлөлийн дарга: Аймгийн ИТХ-ын дарга

Дэд дарга: Аймгийн Засаг дарга

Гишүүд: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
нарийн бичгийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга


Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагийн дарга нар

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг
дарга нар

Нарийн бичиг: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
ажлын албаны нийгмийн бодлого, өргөдөл гомдол
хариуцсан мэргэжилтэн

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт



**Өмнөговь аймгийн нийт ард иргэддээ эв нэгдэл, хөгжлийн
төлөө ШИНЭ БАГ болж ажиллахыг УРИАЛАХ нь:**

Монголчууд бид дэлхийн талыг эзэлсэн агуу түүхтэй ард түмэн. Энэ түүхэн гавьяа бол бидний өвөг дээдэс эрт үеэс, эвийг эрхэмлэн, өөр хоорондоо эвлэлдэн нэгдэж, нягт хамтран ажилласны тод илрэл юм. Түүгээр ч барахгүй түүхэн цаг мөч бүрт Монголчууд бид улс орныхоо сайн сайхан ирээдүйн төлөө нэгэн цул болж чадсанаар өнөөгийн тусгаар тогтносон Монгол орон дэлхийд тунхаглагдсан билээ.

Туурга тусгаар Монгол орны үүдэн хоймор болсон Өмнөговь аймаг маань улсдаа хамгийн том буюу 165 мянган км² өргөн уудам газар нутагтай бөгөөд нийгэм эдийн засгийн голлох салбар болох Уул уурхай, Хөдөө аж ахуйн салбаруудыг даган сүүлийн жилүүдэд манай аймгийн суурин хүн амын тоо эрчимтэй өсч 65 мянгад хүрч, мал сүрэг таван төрлөөр өсч 2 сая 600 мянган толгойд хүрээд байна.

Мөн төрөлх Говь нутагт маань улсдаа хамгийн томд тооцогдох дэлхийд тэргүүлэх хэмжээний нөөцтэй Таван толгойн нүүрсний орд, Нарийн сухайтын чулуун нүүрсний орд болон Оюу толгойн зэс, алтны ордууд үйл ажиллагаа явуулж байна.

Өмнөговьчууд бидэнд эрдэнэт мал сүрэг, түүхийн ховор олдворууд, үзэсгэлэнт байгаль, байгалийн үнэт баялаг, нутгийнхаа нэрийг улсдаа төдийгүй дэлхийд алдаршуулсан урлаг, спортын олон алдартнууд, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн гээд хайрлах, бахархах үнэт зүйл дундаршгүй арвин билээ. Тийм ч учраас өсөж төрсөн, ажиллаж амьдарч байгаа нутаг орондоо говьчууд та бид эв эеэ эрхэмлэн дээдэлж, аймаг, сум, баг, айл хотол, хамт олноороо нэгдэн нягтарч эрүүл энх, эрдэм боловсролтой, элбэг хангалуун, амар тайван аз жаргалтай амьдралын төлөө авьяас чадвар, хүсэл сонирхлоороо бүлэг, хоршоо, нөхөрлөл болж "ШИНЭ БАГ"-т эвлэлдэн нэгдэцгээе.

Өмнөговьчууд бид өнөөгийн ажилгүй, орлогогүй, ядуу тарчиг, стресс, айдастай нийгмийг ардаа орхиж нэг баг, хамт олон болж өөрийн болон бусдын сайн сайхны төлөө сайн үйл хийж байгаа бүхнийг уухайлан ДЭМЖИЦГЭЭЕ.

Аймаг, сум, баг, өрх гэр, албан байгууллага хамт олны хөгжил нь иргэд, олон түмний амьдралд мэдэгдэхүйц байх хэмжээний хамтын ажиллагааг бүх түвшиндээ бий болгон Говь нутгийнхаа хөгжлийн төлөө шат шатандаа ШИНЭ БАГ болж хамтарсан бүлэг нэгдлийг үүсгэж ажиллахыг Өмнөговь аймгийн нийт ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад УРИАЛЖ БАЙНА.

Говь нутгийн ахан дүүс та бид бүгдээрээ сайн сайхан гэрэлт ирээдүйн төлөө чин сэтгэл гарган эвлэлдэн нэгдэж хамтдаа, хөгжлийн шинэ замд хөл нийлүүлэн УРАГШИЛЦГААЯ.